



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/396

Улаанбаатар хот

Салбар хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүрэг бүхий салбар хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Салбар хорооны дарга: Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч

Гишүүд: Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Хэвлэл, мэдээллийн албаны дарга
Статистикийн хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
"Дэлхийн Зөн" Олон Улсын байгууллага
Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан
"Эхлэл АОМ" Төрийн бус байгууллага
"Цогцлох ирээдүй" Төрийн бус байгууллага

Нарийн бичгийн дарга: Нийгмийн хөгжлийн хэлтсийн Жендэр хариуцсан мэргэжилтэн

2. Салбар хорооны ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт даалгасугай.

4. Уг захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/573 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ